

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

(2012 оны 1-р улиралд)

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 1,7 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө нь 32.4 хувиар давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.6 тэрбум төгрөгөөр доогуур гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 1.3 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.8 хувиар дээгүүр гүйцэтгэлтэй байна.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хас, Хадгаламж, Голомт банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 36.6 тэрбум төгрөгт хүрсэн нь оны эхнээс 1.5 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл 18.0 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 1.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 7.0 хувь болох 63.7 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.0 хувь болох 63.3 мянган төл бойжиж байна.

Оны эхний малын 0.2 хувь болох 4.6 мянган мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 99.8 хувьтай байна.

Нийт хорогдлын 54.8 хувь нь ямаа, 38.0 хувь нь хонь эзэлж байна.

Сүхбаатар сумаас бусад сумдын оны эхний малын 0.1-1.1 хувь болох 4.6 мянган толгой мал хорогдоод байгаа нь нийт хорогдлын 99.2 хувийг эзэлж байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 9.7 тэрбум төгрөг болж, урьд оны мөн үеийнхээс 2.3 тэрбум төгрөгөөр дээгүүр байна.

Оны үнээр 39.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 7.9 тэрбум төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, хэвийн боов, ганбургер, нүүрс, цайрын баяжмалын үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

V. ТЭЭВЭР, ХОЛБОО: Тээвэр: Тээвэр бүхий байгууллагууд 11.9 сая.тн.км-ийн ачаа эргэлт, 8.8 сая.хүн.км-ийн зорчигч эргэлт хийж, 1.7 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.

Холбоо: Холбоо ашиглалтын орлого 112.1 сая төгрөгт хүрсний дотор 38.8 сая төгрөг нь хүн амаас орсон байна. Телефон цэгийн тоо 864 байна.

VI. СОЁЛ: Хөгжимт жүжгийн театр 7.3 мянган үзэгчдэд 9 тоглолтоор үйлчилж 2.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Музей: 1.8 мянган үзмэрээр 0.2 мянган хүнд үйлчилж, 170.5 мянган төгрөгийн орлого олжээ.

Нийтийн номын сан: 7.1 мянган уншигчдад 42.8 мянган номоор үйлчилж 130.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

VII. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 3-р сард оны эхнээс 5 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 7.9 хувиар өсч түүн дотор талх, гурил, будаанаас бусад нэр төрлийн үнэ 0.1-39.6 хувиар өссөн байна.

Мөн боловсролын үйлчилгээнээс бусад бүх бүлгийн үнэ, тариф 0.3-12.2 хувиар өссөн байна.

VIII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 1.5 тэрбум төгрөг болж, төлөвлөгөө 29.2 хувиар давж биелэв. Сайн дурын даатгуулагчид 31 сая төгрөгний шимтгэл оруулсан байна. 6100 өндөр настанд 2.0 тэрбум төгрөгийн тэтгэврийг бүрэн олгосон байна. Нийгмийн халамжийн сангаас 0.4 тэрбум төгрөгийг 3.9 мянган иргэнд, улсын төсвөөс 4.4 тэрбум төгрөгийг давхардсан тоогоор 60.7 мянган иргэнд тус тус олгосны дотор хүний хөгжил сангаас 3.7 тэрбум, төгрөгийг 54.5 мянган иргэнд олгосон байна.

IX. ЭРҮҮЛ МЭНД: Оны эхний 3 сард 333 эх амаржиж, 335 хүүхэд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр байна.

Халдварт өвчнөөр 156 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 19-өөр олон байгаа бөгөөд гепатит, салхинцэцэг, тэмбүү, трихоминиаз зэрэг өвчлөлтүүд өссөн байна.

X. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 892 болж, оны эхнээс 80 хүнээр өссөн байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 76.1 хувь нь 16-34 насны залуучууд байна. Боловсролын түвшинээр авч үзвэл 21.3 хувь нь дээд, 2.8 хувь нь тусгай дунд, 40.5 хувь нь бүрэн дунд, 7.1 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 3 сард 240 хүн шинээр бүртгүүлж, 155 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 151 хүн ажиллаж байна.

XI. ГЭМТ ХЭРЭГ: Оны эхний 3 сард 49 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 10-аар дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 7 хүн нас барж, 15 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 18.7 сая төгрөгийн хохирол учирсны 15.6 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 38 хүн холбогдон сэжиглэгдсэний 34.2 хувь нь согтуугаар, 15.8 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 798 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеэс 60 хүнээр олон байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 38 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

XII. МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ ТӨСӨЛ: Энэ онд 13 суманд 4 даатгалын нэгжийн 86 төлөөлөгч ажиллах эрхээ аваад байна.

2012 оны эхний 3 сарын байдлаар малын индексжүүлсэн даатгал хийгдээгүй байна.

XIII. ДААТГАЛ: Даатгалын байгууллагуудын хураамжийн орлого 20.2 сая төгрөг болж, төлөвлөгөө нь 77.6 хувиар давж биелсэн байна. 109 хүнд 4.2 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосны дотор авто тээврийн хэрэгсэлд 0.9 сая, гэнэтийн осолд 1.2 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 1.1 сая төгрөгийг тус тус олгожээ.

XIV. ТӨСЛҮҮДИЙН ЗЭЭЛ ОЛГОЛТ: ХХҮХ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 252 хүнд 239.3 сая төгрөгийн зээл олгожээ.

XV. ГАЗАР ӨМЧЛӨЛ: Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 6076 иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 5917 иргэнд 559.9 га газар өмчлүүлэх шийдвэр гараад хэрэгжиж байгаагийн дотор энэ оны эхний 3 сард 61 иргэн өргөдөл гаргаж, 66 иргэнд 6.7 га газрыг өмчлүүлэх шийдвэр гаргасан байна.

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН

ДАРГА  О.ЦЭРЭНДУЛАМ

